



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР


САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/62/СТА/ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2020 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyma@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: nbunchin0719@gmail.com</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	14
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	15
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	17



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Ауд.од.д.д. № 1/2017

тантай _____ -ны № _____ -т

Г Аудитын гэрчилгээ 1

Г БАЯНХОНГОР СУМЫН 6 ДУГААР 1
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Д. МӨНХЗУЛ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\ 005020162


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Д.Мөнхзул Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дах Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 09 ний өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Удирдлагын менежментийг боловсронгуй болгон, хүний нөөцийн чадавхыг сайжруулж, эцэг, эх олон нийтийн оролцоог идэвхжүүлэн улсын тэргүүний цэцэрлэг болох, сургуулийн өмнөх боловсролд 2-5 насны хүүхдийг бүрэн хамруулж сургалтыг чанартай явуулан, бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг хангасан, цогц чадамж төлөвшсөн хүүхдийг сургуульд бэлтгэх”-д оршино

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хоёр наснаас сургуульд элсэх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих
- Хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт зохион байгуулж, эцэг эх, асран хамгаалагчдад мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 25 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 499,940.8 мянган төгрөгөөс 9998,8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,136,546.1 мянган төгрөгөөр буюу 233 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	49,619.7	73,003.7	23,384.1
Үндсэн хөрөнгө	466,590.8	1,597,444.3	1,130,853.5
Хуримтлагдсан элэгдэл	-28,260.2	-45,951.6	-17,691.5
Нийт хөрөнгө	487,950.3	1,624,496.4	1,136,546.1
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	487,950.4	1,624,496.4	1,136,546.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	487,950.4	1,624,496.4	1,136,546.1

Бараа материалын дансны үлдэгдэл 23,384.1 мянган төгрөг өссөн нь аж ахуйн материал 13021,1 мянга, хүнсний материал 763,0 мянга, бусад хангамжийн материал 9891,5 мянган төгрөг өссөнөөс шалтгаалжээ. Аж ахуйн материал 13021,1 мянган төгрөгөөр өссөн нь НҮБ-аас гал тогооны хэрэгсэл 8422,0 мянга, тооллогоор 1726,5 мянга, төсвийн хөрөнгөөр аяга тавагны ком 2378,2 мянган төгрөгөөр бэлтгэснээс шалтгаалсан байна. Бусад хангамжийн материал 9891,5 мянган төгрөгөөр өссөн нь тооллогоор илэрсэн 2783,8 мянга, БСШУСЯ-наас хүүхдийн ширээ сандал 1225,9 мянга, төсвийн хөрөнгөөр зөөлөн эдлэл 4994,8, сургалтын хэрэглэгдэхүүн 887,0 мянган төгрөгөөр бэлтгэснээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1130853,5 мянган төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1094523,4 мянган төгрөгийн өртөгтэй 150 хүүхдийн өргөтгөлийн барилга ашиглалтад орсон, НҮБ-аас тавилга, тоног төхөөрөмж 29520,0 мянга, аймгийн ЗДТГ-аас 2000,0 мянган төгрөгийн гэр, тооллогоор илэрсэн 3724,0 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна. Мөн үндсэн хөрөнгөөс аймгийн ИТХ-ын 2019 оны 12 сарын 25-ны өдрийн 129 дугаар тогтоолоор 3724,0 мянган төгрөгийн хөрөнгө акталсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1624496.4 мянган төгрөг болж 1136546.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 1136546,1 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх сургуулийн өмнөх боловсрол олгох хөтөлбөрт зориулан 482170,6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 482170,6 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 440704,2 мянган төгрөгийг тусгай зориулалтын санхүүжилтээс, 41466,4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 482170,6 мянган төгрөг буюу 100 хувь төсвийг зарцуулсан байна.

Нэмэлт төсөв: Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 7797,6 мянган төгрөгийн орлого орсон үүнээс 2 багшийн 6 сарын тэтгэмж 6447,6 мянган төгрөг, Баянхонгор сумаас хүүхдэд ээлтэй цэцэрлэгийн шагнал 900,0 мянган төгрөг, ногоон байгууламж эко аяны шагнал 450,0 мянган төгрөг орж зарцуулсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 25 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 25 эрсдэл тодорхойлж нийт 25 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 5631,5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 3350,6 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 2280,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал
(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	2280,9	
2	Төлбөрийн акт тогтоосон	3	3350,6	
3	Албан шаардлага өгсөн			
	Дүн	4	5631,5	

Аудитаар дараах 5631,5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3350,6 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо Үүнд:

1. Тус цэцэрлэгт тэтгэвэр тогтоолгон гэрээгээр ажиллаж байгаа эмч Л.Баасанбатын 2019 оны 3-12 сарын цалин хөдөлмөрийн хөлс болох 5507,7 мянган төгрөгөөс 512,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл суутгаагүй, ажил олгогчоос төлөх 567,3 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг төлөөгүй зөрчил илэрлээ.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь заалтад Ажил олгогч иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Тус цэцэрлэг нь хоолны зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргалгүй 2202,7 мянган төгрөгийн хүнсний материал нөөцөлж санхүүгийн тайланд тусгасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2012 оны 106 дугаар тогтоолын 4-т “Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд өдрөөр хянаж зөрүүг тооцож байх” гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

3 Хоолны зардлаас нягтлан бодогч нь анхан шатны баримтгүйгээр 68,4 мянган төгрөгийг шууд зарлагдсан зөрчил илэрлээ.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 7 дахь заалт "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

Аудитаар илэрсэн 2280,9 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цаашид анхан шатны баримт бүрдэлгүй зардал гаргаж байгаа байдлыг төслөн зогсоож, үүнийг давтан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 113 мэдээллийг хугацаанд нь, 38 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд байршуулсан	Хугацаа хоцроож байршуулсан	Байршуулаагүй
1	Бүтэн жил	11	11	11		
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	1	3	
4	Сар бүр	3	36	36		
5	Тухай бүр	8	96	61	35	
6	Нийт	27	151	113	38	

Улирал бүр мэдээлэх 4 мэдээллээс 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба энэ нь төсөв гүйцэтгэл хэсгийн "Батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт" мэдээллийн 3 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Тухай бүр мэдээлэх 96 мэдээллээс 35 мэдээллийн хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь төсөв гүйцэтгэл хэсгийн тухай бүр мэдээлэх мэдээллээс 16 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер хэсгийн тухай бүр мэдээллээс 18 мэдээлэл, бусад мэдээлэл хэсгийн тухай бүрээс 1 мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан байна.

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөөгүй байна

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

"Зөрчилгүй" дүгнэлт

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Төсвийн төлөвлөлт гүйцэтгэлтэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Тухайн тайлант хугацаанд 482170,6 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 482170,6 мянган төгрөг зарцуулсан байна. Халаалтын зардал 1900,9 мянган төгрөгөөр хэтэрсэн шалтгааныг судалж үзэхэд халаалтын талбайн хэмжээг дахин хэмжиж талбай нэмэгдсэнээр зардалд нэмэгджээ. Мөн цалингийн сангаас хамтын гэрээнд тусгагдсаны дагуу жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт зориулан 380,0 мянган төгрөг олгосон байна.

1.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв зориулалтын дагуу зарцуулагдахгүй байх, төсөв хэтрэх

1.3. Өгсөн зөвлөмж:

Халаах талбайн хэмжээг мэргэжлийн байгууллагаар хэмжүүлэн халаалтын зардлыг тооцох, цалингийн сангаас нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг гаргахгүй байх

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>49,619,668.47</u>	<u>73,003,745.82</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	49,619,668.47	73,003,745.82
351	Түүхий эд материал	7,736,713.40	7,093,723.52
35110	Тусгай зориулалттай материал	7,726,213.40	7,045,583.52
35130	Эм боох материал	10,500.00	48,140.00
354	Хангамжийн материал	41,882,955.07	65,910,022.30
35410	Бичиг хэргийн материал	3,273,104.00	3,299,584.00
35420	Аж ахуйн материал	33,761,210.67	46,782,321.51
35450	Барилгын засварын материал	00.00	325,000.00
35460	Хүнсний материал	1,439,900.00	2,202,866.80
35470	Бусад хангамжийн материал	3,408,740.40	13,300,249.99
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>438,330,684.76</u>	<u>1,551,415,443.68</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	438,330,684.76	1,551,415,443.68
392	Биет хөрөнгө	387,613,914.14	1,500,786,867.54
39201	Барилга, байгууламж, орон сууц	355,259,805.58	1,450,483,205.58
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-14,056,743.96
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29,171,270.00	55,845,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-16,068,430.28	-16,811,726.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,974,771.46	39,930,427.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,723,502.62	-14,603,964.72
393	Биет бус хөрөнгө	50,716,770.62	50,628,576.14
39301	Програм хангамж	725,000.00	725,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-468,229.38	-556,423.86
39303	Бусад биет бус хөрөнгө	50,460,000.00	50,460,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>487,950,353.23</u>	<u>1,624,419,189.50</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>487,950,353.23</u>	<u>1,624,419,189.50</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	487,950,353.23	1,624,419,189.50
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	164,218,577.00	164,218,577.00
51101	Өмч: - төрийн	164,218,577.00	164,218,577.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,650,683.78	1,140,119,520.05
51210	Өмнөх үеийн үр дүн	3,650,683.78	3,650,683.78
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	1,136,468,836.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	320,081,092.45	320,081,092.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>487,950,353.23</u>	<u>1,624,419,189.50</u>

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	463,533,976.90	1,636,486,829.59
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,600,000.00	1,146,518,629.59
120	Нийтлэг татварын бус орлого	7,600,000.00	1,146,518,629.59
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,600,000.00	1,146,518,629.59
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,400,000.00	1,146,518,629.59
120009	Бусад орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	455,933,976.90	489,968,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	450,488,400.00	440,704,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	450,488,400.00	440,704,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,483,994.90	7,797,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,483,994.90	6,447,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	41,466,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	41,466,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	455,057,761.03	499,942,993.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	455,057,761.03	499,942,993.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	418,544,192.61	493,084,585.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,577,785.10	293,037,988.00
210101	Үндсэн цалин	240,577,785.10	293,037,988.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,750,391.88	36,980,504.00
210201	Тэтгэврийн даатгал	18,756,319.07	25,704,774.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,334,076.00	2,874,042.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,867,258.81	2,299,235.00
210204	Ажилгүйдлийн даатгал	435,705.00	554,769.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,357,033.00	5,547,684.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,339,785.00	38,726,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,935,995.00	4,780,167.00
210302	Түлш, халаалт	45,953,790.00	25,756,180.00
210303	Цэвэр, бохир ус	7,450,000.00	8,190,053.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,445,364.83	7,720,259.04
210401	Бичиг хэрэг	1,582,100.00	775,920.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	280,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,087,731.50	1,108,865.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,775,533.33	2,471,604.16
210408	Бараа материал акталсны зардал	00.00	2,903,869.88
2105	Нормативт зардал	78,297,309.40	78,460,693.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	71,100.00	56,660.00
210502	Хоол, хүнс	78,226,209.40	78,404,033.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	323,300.00	13,027,450.00
210604	Урсгал засвар	323,300.00	13,027,450.00

2107	Томилолт, зочны зардал	196,800.00	1,796,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	196,800.00	196,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	702,000.00	2,175,850.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	702,000.00	2,175,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,911,456.40	21,158,641.16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	305,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,326,156.40	20,853,141.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,513,568.42	6,858,408.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,488,782.00	6,858,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,279,200.00	6,447,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	210,000.00	410,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.60	08.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.60	08.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,476,215.87	1,136,543,836.19
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	6,292,772.15	74,999.92
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	74,999.92
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-6,292,772.15	-74,999.92
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	2,183,443.72	1,136,468,836.27

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	456,133,976.90	489,968,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	455,933,976.90	489,968,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	450,488,400.00	440,704,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,483,994.90	7,797,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	1,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	2,483,994.90	6,447,600.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	41,466,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	41,466,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	456,133,976.90	489,968,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	456,133,976.90	489,968,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	419,519,608.48	483,109,792.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	238,104,849.78	292,682,892.00
210101	Үндсэн цалин	214,081,949.78	245,323,092.00
210102	Нэмэгдэл	10,091,100.00	25,834,600.00
210104	Урамшуулал	13,931,800.00	21,525,200.00

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,803,874.00	37,335,600.00
210201	Тэтгэврийн даатгал	19,137,187.00	25,868,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,182,200.00	2,866,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,745,800.00	2,293,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	430,600.00	599,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,308,087.00	5,707,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,049,785.00	38,666,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,935,995.00	4,780,167.00
210302	Түлш, халаалт	45,663,790.00	25,696,180.00
210303	Цэвэр, бохир ус	7,450,000.00	8,190,053.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,243,981.50	4,757,200.00
210401	Бичиг хэрэг	189,800.00	323,100.00
210402	Тээвэр, шатахуун	290,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,038,231.50	1,108,865.00
210404	Ном, хэвлэл	105,400.00	105,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,620,550.00	2,699,835.00
2105	Нормативт зардал	85,644,165.00	85,106,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,400.00	94,300.00
210502	Хоол, хүнс	78,300,465.00	79,167,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,245,300.00	5,845,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	323,300.00	18,304,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	2,378,200.00
210604	Урсгал засвар	323,300.00	15,926,500.00
2107	Томилолт, зочны зардал	196,800.00	1,796,800.00
210701	Гадаад албан томилолт	00.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	196,800.00	196,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,516,400.00	2,680,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,516,400.00	2,430,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,636,453.20	1,778,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	130,300.00	1,778,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,614,368.42	6,858,408.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,589,582.00	6,858,400.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,279,200.00	6,447,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	310,800.00	410,800.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.60	08.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.60	08.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	113,758,577.00	43,830,795.04	-15,483,990.04	142,105,382.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	113,758,577.00	43,830,795.04	-15,483,990.04	142,105,382.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	30,813,608.08	30,813,608.08
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	3,650,683.78	487,950,353.23
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	3,650,683.78	487,950,353.23
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	3,650,683.78	487,950,353.23
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	1,136,468,836.27	1,136,468,836.27
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	164,218,577.00	320,081,092.45	1,140,119,520.05	1,624,419,189.50

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	482,170,600.00	482,170,592.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	482,170,600.00	482,170,592.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	481,759,800.00	481,759,792.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	292,456,700.00	292,682,892.00
210101	Үндсэн цалин	245,096,900.00	245,323,092.00
210102	Нэмэгдэл	25,834,600.00	25,834,600.00
210104	Урамшуулал	21,525,200.00	21,525,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,335,600.00	37,335,600.00
210201	Тэтгэврийн даатгал	25,868,700.00	25,868,700.00

Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210202	Тэтгэмжийн даатгал	2,866,800.00	2,866,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,293,300.00	2,293,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	573,400.00	599,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,733,400.00	5,707,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	38,666,400.00	38,666,400.00
210301	Гэрэл, цахилгаан	4,399,200.00	4,780,167.00
210302	Түлш, халаалт	23,795,200.00	25,696,180.00
210303	Цэвэр, бохир ус	10,472,000.00	8,190,053.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,757,200.00	4,757,200.00
210401	Бичиг хэрэг	264,800.00	323,100.00
210402	Тээвэр, шатахуун	340,000.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,461,400.00	1,108,865.00
210404	Ном, хэвлэл	105,400.00	105,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	180,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,405,600.00	2,699,835.00
2105	Нормативт зардал	85,110,700.00	85,106,600.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	98,400.00	94,300.00
210502	Хоол, хүнс	79,167,000.00	79,167,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,845,300.00	5,845,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,526,800.00	18,304,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,600,000.00	2,378,200.00
210604	Урсгал засвар	15,926,800.00	15,926,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,796,800.00	1,796,800.00
210701	Гадаад албан томилолт	1,600,000.00	1,600,000.00
210702	Дотоод албан томилолт	196,800.00	196,800.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,330,900.00	1,330,900.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,080,900.00	1,080,900.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	250,000.00	250,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,778,700.00	1,778,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,778,700.00	1,778,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	410,800.00	410,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	410,800.00	410,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	410,800.00	410,800.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	482,170,600.00	482,170,592.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	440,704,200.00	440,704,192.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	440,704,200.00	440,704,192.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,466,400.00	41,466,400.00
132001	Орон нутгийн төсвөөс	41,466,400.00	41,466,400.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	32.00	32.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	18.00	18.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	280.00	280.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	280.00	280.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	280.00	280.00



4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,797,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,797,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1350000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6447600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,447,600.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	6,447,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7797600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	7,797,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,350,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	6,447,600.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:

Н.Бунчинсүрэн

Н.БҮНЧИНСҮРЭН 2020.02.25

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.Цээням

А.ЦЭЭНЯМ 2020.02.25

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.Мөнхбат

Б.МӨНХБАТ 2020.02.25

